

БАТЛАВ.
НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВИЙН
ДАРГА.....С.АРИУНБОЛД
ОГНОО:.....



НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВ

**ХООЛ ХҮНСНИЙ МАТЕРИАЛ ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР
ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалтын нэр: Хоол хүнсний хангамжийн материал худалдан авах тендер

Тендер шалгаруулалтын дугаар: НТТТ/202401003

Улаанбаатар хот
2024.01.31

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)	1
1. Тендерийн цар хүрээ	1
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг	1
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж	1
4. Сонирхогч этгээд, оролцогч	2
5. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ	2
6. Нийлүүлэх барааны гарал үүсэл	2
7. Тендер шалгаруулалтын баримт бичиг	3
8. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах	3
9. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт	3
10. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл	4
11. Тендерийн иж бүрдэл	4
12. Тендерийн жишиг маягтууд	5
13. Хувилбарт санал	5
14. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг	5
15. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг	6
16. Чадавхын болон туршлагын шаардлага	7
17. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт	8
18. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт	9
19. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт	9
20. Тендерийн валют	10
21. Тендер хүчинтэй байх хугацаа	10
22. Тендерийн баталгаа	10
23. Тендер баталгаажуулах, илгээх	10
24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа	11
25. Тендерийн талаар тодруулга авах	11
26. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх	11
27. Тендерийг үнэлэх	11
28. Арифметик алдааг залруулах	11
29. Оролцогчид давуу эрх олгох	12
30. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт	12
31. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох	12
32. Тендерийг эрэмбэлэх	12
33. Оролцогчийн чадавхыг дахин магадлах	12
34. Мэдэгдэл хүргүүлэх	12
35. Гүйцэтгэлийн баталгаа	13
36. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах	13

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- | | | |
|--|-------------------|---|
| 1. Тендерийн хүрээ | цар | <p>1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “бараа” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.</p> <p>1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.</p> <p>1.3. Барааг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой багцын барааг хуулийн 8.1-д зааснаар дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой бол энэ тухай захиалагч өгөгдлийн хүснэгтэд заана. Ийнхүү заасан бол тендер шалгаруулалт, эсхүл түүний багцад зөвхөн Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлнэ.</p> <p>1.4. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгт болон зарлалд заана.</p> |
| 2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг | болон | <p>2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.</p> |
| 3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж | авах | <p>3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.</p> |
| 4. Худалдан авах ажиллагааны цахим систем | авах | <p>4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.</p> |
| 5. Авлига, сонирхлын зөрчлөөс байх | ашиг ангид | <p>5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.</p> |

- 5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.
- 6. Сонирхогч этгээд, оролцогч**
- 6.1. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.
- 6.2. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.
- 6.3. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.
- 6.4. Тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т заасан үйлчилгээний хураамж төлсөн байна.
- 6.5. ТШЗ-ны 6.4-т заасан үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.
- 7. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ**
- 7.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.
- 7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.
- 7.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.
- 7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.
- 7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 8. Нийлүүлэх барааны гарал үүсэл**
- 8.1. ТШЗ-ны 1.3-т өөрөөр заагаагүй бол гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.

Б. АГУУЛГА

9. Тендер шалгаруулалтын баримт бичиг

9.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:
I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;
II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;
III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;
IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;
V Бүлэг. Тендерийн жишиг маягт;
VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

9.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

9.3. Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн тендер бэлтгэнэ.

10. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах

10.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтийг хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар захиалагчид гаргах бол Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүргүүлнэ.

10.2. ТШЗ 10.1-д заасан хүсэлтэд ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд болохыг нотлох баримтыг хавсаргана.

10.3. Тодруулгын дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл захиалагч хуулийн 20.6-д заасны дагуу шийдвэрлэнэ.

11. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт

11.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана. Захиалагч уулзалтад ТШЗ-ны 6.6-д заасан сонирхогч этгээд, түүний төлөөллийг оролцуулна.

11.2. ТШЗ-ны 11.1-д заасан уулзалтад оролцоогүй нь аж ахуй эрхлэгчийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

12.Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл

- 12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.
- 12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн ТШЗ-ны 12.1-д заасан хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.
- 12.3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн хэл болон гадаад хэлээрх хувилбар хоорондоо зөрвөл ТШЗ-ны 12.1-д заасан хэлээр бэлтгэсэн тендер шалгаруулалтын баримт бичгийг баримтална.
- 12.4. Захиалагч ТШЗ-ны 12.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

13.Тендерийн бүрдэл

- иж 13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн бараа нийлүүлэх техникийн болон үнийн санал байна.
- 13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:
- 13.2.1. ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэсэн маягтууд;
- 13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;
- 13.2.3. захиалагч зөвшөөрсөн бол ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;
- 13.2.4. оролцогч ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

- 13.2.5. санал болгож буй бараа ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;
- 13.2.6. бараа нийлүүлэлтийн хуваарь;
- 13.2.7. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 18, ТШЗ 19, ТШЗ 20 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;
- 13.2.8. ТШЗ-ны 21 дүгээр зүйлд заасан барааны үнийн задаргаа;
- 13.2.9. ТШЗ-ны 21.9-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;
- 13.2.10. түншлэл бол хуулийн 6.3-т заасан түншлэлийн гэрээ.
- 13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.
- 13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.
- 14. Тендерийн жишиг маягтууд** 14.1. Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтын дагуу илгээнэ.
- 15. Хувилбарт санал** 15.1. Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан заасан тохиолдолд оролцогч хуулийн 11.10-т заасанд нийцэх хувилбарт саналыг тендерт ирүүлж болно.
- 16. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг** 16.1. Оролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.
- 16.2. Монгол Улсын хуулийн этгээд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ.
- 16.3. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:
- 16.3.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;
- 16.3.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

- 16.3.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.
- 16.4. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 14.2, 14.3-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.
- 17. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг**
- 17.1. Нийлүүлэхээр санал болгох барааны гарал үүслийн мэдээллийг V бүлгийн Маягт 2-ын холбогдох хэсэгт бөглөж ирүүлнэ.
- 17.2. Хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй.
- 17.3. Оролцогчийн санал болгож буй бараа нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлох баримтыг өгөгдлийн хүснэгтэд зааснаар тендерт ирүүлнэ.
- 17.4. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол оролцогч өөрийн санал болгож байгаа бараанд холбогдох загвар, дээжийг тендер нээх эцсийн хугацаанаас өмнө захиалагчид хүргүүлэх ба шалгалт, туршилтыг хийх ажиллагаанд оролцогчийг өгөгдлийн хүснэгтэд зааснаар оролцуулна.
- 17.5. Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно. Санал болгох бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэнийг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг техникийн тодорхойлолттой нийцсэн болохыг хянан үзэх боломжтой баримт, хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарласан тайлбар ирүүлсэн байна.
- 17.6. Барааг нийлүүлснээс хойш өгөгдлийн хүснэгтэд заасан хугацааны туршид тасралтгүй, горимын дагуу ашиглахад шаардагдах өгөгдлийн хүснэгтэд заасан сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалтыг тэдгээрийг авах боломжтой хаяг, үнийн мэдээллийн хамт ирүүлнэ.

- 17.7. Техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал, тоног төхөөрөмжийн загвар, хэмжих нэгж, стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар зэрэг нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.
- 17.8. Гадаадын этгээдийн хувьд гэрээний дагуу хийгдэх техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлөгч гүйцэтгэх тухай баримт;
- 17.9. Монгол Улсын гарал үүсэлтэй бус бараа нийлүүлэхээр санал болгосон оролцогч нь техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээлэл;
- 17.10. Хуулийн 8.4-т зааснаар давуу эрх тооцуулах барааны Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлснээр Сангийн сайдын баталсан Давуу эрх олгох аргачлал, зааврын дагуу тооцно. Барааны үнийн задаргаанд Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг заагаагүй, эсхүл гарал үүслийг нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх тооцохгүй.
- 17.11. ТШЗ-ны 1.3-т зааснаар нийлүүлэхээр санал болгох бараа Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Нотлох баримт бичиг ирүүлээгүй тохиолдолд тухайн барааг шаардлага хангаагүй гэж үзнэ.
- 17.12. Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс нийлүүлэхээр санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 18.1. Захиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн хүснэгтэд заах ба хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална.

18. Чадавхын туршлагын шаардлага

болон

- 18.2. Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана. Тухайн бараа, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг захиалагч шаардсан бол түншлэлийн гишүүн тус бүр уг шаардлагыг хангасан байх шаардлагатай. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.
- 18.3. Түншлэл нь ТШЗ-ны 18.1-д заасан доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. Борлуулалтын орлогын хэмжээ, ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг ТШЗ-ны 18.1-д заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
- 18.4. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.
- 19.1. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 19.2. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.
- 19.3. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

**19. Санхүүгийн
чадавхын
шаардлагыг хангах
нотлох баримт**

- 20. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**
- 20.1. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.
- 21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**
- 21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.
- 21.2. Барааны үнийн задаргаанд багц тус бүрийн барааны нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг тусгаж ирүүлнэ.
- 21.3. Оролцогч үнийн хөнгөлөлт санал болгох бол ТШЗ-ны 14-т заасан тендер илгээх маягтад заана.
- 21.4. ТШЗ 21.3-т зааснаар үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг тендерийн үнэ гэж үзнэ.
- 21.5. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.
- 21.6. Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
- 21.7. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
- 21.8. ТШЗ-ны 21.2-т заасан барааны үнийн задаргааны нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч тендер илгээх маягтад үнээс зөрүүтэй бол барааны үнийн задаргааны нийт нийлбэрийг тендер илгээх маягтын үнэ гэж үзнэ.

- 21.9. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.
- 22. Тендерийн валют** 22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.
- 23. Тендер хүчинтэй байх хугацаа** 23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.
- 23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.
- 23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.
- 24. Тендерийн баталгаа** 24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 24.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрээр ТШЗ-ны 24.1-д зааснаар ирүүлнэ.
- 24.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.
- Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ**
- 25. Тендер баталгаажуулах, илгээх** 25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.
- 25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

- 25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.
- 25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 6-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.
- 25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.
- 26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**
- 26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.
- 26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.
- Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ**
- 27. Тендерийн талаар тодруулга авах**
- 27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.
- 28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх**
- 28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасан иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн хянан үзнэ.
- 29. Тендерийг үнэлэх**
- 29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.
- 29.2. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.
- 30. Арифметик алдааг залруулах**
- 30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.
- 30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

- 31. Давуу эрх олгох**
- 31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн дотоодын бараанд хуулийн 8.4-т зааснаар давуу эрх олгож, дотоодын барааны хэсгийн үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.
- 31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.
- 31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.
- 32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт**
- 32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
- 33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох**
- 33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална.
- 33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ.
- 33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
- 34. Тендерийг эрэмбэлэх**
- 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.
- 35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах**
- 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадална.
- 35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 19 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 20 дугаар зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.
- 35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.
- Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ**
- 36. Шийдвэр хүргүүлэх**
- 36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.

**37. Гүйцэтгэлийн
баталгаа**

37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.

37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.

**38. Гэрээнд гарын үсэг
зурж
баталгаажуулах**

38.1. Захиалагч ТШЗ-ны 9.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.

38.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ӨХ)

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: Нийслэлийн түргэн тусламжийн төв
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: Хоол хүнсний хангамжийн материал худалдан авах
ТШЗ 1.1	Тендерийн урилгын дугаар: НТТТ/202401003
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй
ТШЗ 1.3	Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бич: Дотоодын багц № : Байхгүй
ТШЗ 1.4	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “Үгүй”
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Тухайн байгууллагын өөрийн хөрөнгөөр
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 632,529,400 /Зургаан зуун гучин хоёр сая таван зуун хорин есөн мянга дөрвөн зуу/
	Б. АГУУЛГА
ТШЗ 8.1	Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг: Хүлээн авагчийн нэр: Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга Ж.Нямпүрэв Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чин ван Чагдаржавын гудамж, Нийслэлийн түргэн тусламжийн төв Утасны дугаар: 11-321811, 88297070
ТШЗ 11.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “Үгүй”
	В. ТЕНДЕР БЭЛТГЭХ
ТШЗ 12.2	Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэл: “Монгол хэл”
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: “Зөвшөөрөхгүй”
ТШЗ 17.4	Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж ирүүлэх эсэх: “Үгүй”
ТШЗ 17.6	Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх эсэх, ирүүлэх бол хугацаа: “Үгүй”
ТШЗ 18.1	Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн шаардлага, шалгуур үзүүлэлт: “Шаардахгүй” Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: “Шаардлагатай” <ul style="list-style-type: none"> 2023 он. Уг тендерийн батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээ доод тал нь 1 удаа ирүүлэх. Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шаардлага: “Шаардана.” <ul style="list-style-type: none"> Ачааны машин 1 ширхэг /Бараа зөөх/ Тухайн машин нь тухайн байгууллагын юм уу өмчлөгчийн нэр дээр байх. /Бичиг баримтыг хавсаргах/

	<p>Агуулах байр /хүнс хадгалах зориулалт бүхий агуулах/</p> <ul style="list-style-type: none"> • Мах, махан бүтээгдэхүүн хадгалах хөргүүртэй агуулах байр- 1 • Хүнсний бүтээгдэхүүн хадгалах агуулах байр-1 <p>Агуулах байр нь тухайн байгууллагын болон өмчлөгчийн нэр дээр байх. /Нотлох бичиг баримтыг хавсаргах/ Эсвэл нийлүүлэлтийн хугацаа дусах хүртэлх түрээслэхийг баталсан бичиг баримтыг нотариатаар баталгаажуулж ирүүлэх.</p> <p>Оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> • Борлуулалтын орлогын хэмжээ: 2023 оны гүйцэтгэсэн борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсвийн 70 хувиас багагүй байх <p>Оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага: “Шаардахгүй”</p>
ТШЗ 18.2	Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: “Шаардахгүй”
ТШЗ 19.1	<p>Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: “Тийм”</p> <p>“Тийм” гэж хариулсан бол санхүүгийн чадавхтай холбоотойгоор хуулийн 16.2, 16.4-т заасан дараах баримт бичгээс сонгож шаардаж болох ба бусад баримт бичиг шаардахыг хуулиар зөвшөөрөөгүй болохыг анхаарна уу. Сүүлийн гурав хүртэл жилээс аль аль оны мэдээллийг шаардахыг тодорхой заана.</p> <ul style="list-style-type: none"> • Харилцагч банкны мэдэгдэл ирүүлэх /өр, зээлтэй эсэх талаар/ Хугацаа хэтэрсэн зээлгүй талаар дурдсан байх. • Монгол Улсын хуулийн дагуу татвар, даатгал, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын, нийгмийн даатгалын, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолтуудыг ирүүлэх шаардлагагүй бөгөөд худалдан авалтын цахим системээс өр, төлбөрийн талаарх мэдээллийг тендер нээсэн өдрийн байдлаар шалгах тул өр, төлбөргүй байх шаардлагатай. • 2023 оны жилийн санхүүгийн тайлан /Цахимаар шалгана./ • Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: 2023 он • Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод байх шаардлагатай.
ТШЗ 20.1	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэх эсэх: “Үгүй”</p> <ul style="list-style-type: none"> • Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /Гадаад худалдаа/ • Шүүхийн төрөлжсөн архивын лавлагаа ирүүлнэ. /Цахимаар/ • Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолтыг ирүүлнэ. /Цахимаар/

	<ul style="list-style-type: none"> • <i>Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээллэхэд татгалзах зүйлгүй тухай албан мэдүүлэг ирүүлнэ.</i> • Техникийн тодорхойлолтын дагуу шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүнийг шинэ, шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнээр солих үүрэг хүлээх тухай тодорхойлолт ирүүлнэ. • Хүнсний бүтээгдэхүүнийг бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу нийлүүлэх бүрд тухайн барааны эрүүл ахуйн шаардлага хангасан бичиг ирүүлэхийг зөвшөөрсөн мэдэгдэл ирүүлэх. • Техникийн тодорхойлолтод барааны гарал үүсэл, компани, савлалт хэмжээ зэргийг дэлгэрэнгүй бичиж оруулсан байна. <p>Оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: “Шаардахгүй”</p>
ТШЗ 21.5.	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулахгүй тогтмол байна”
ТШЗ 21.6	Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: “Тийм” Incoterms 2020, DDP
ТШЗ 24.1	Тендерийн баталгааны дүн: 3,162,647 төгрөг
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 25.5.	Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл; Санал болгосон барааг нийлүүлэх боломжтой болохыг нотлох баримт Тендерт оролцогчийн сүүлийн 3 жилийн хугацаанд оролцсон иргэний хэрэг, маргааны талаар шүүхийн архивын байгууллагаас холбогдох дүрэм, журмын хүрээнд гаргасан тодорхойлолт;
ТШЗ 26.1.	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдөр Цаг: 09 цаг 00 минут
ТШЗ 26.2.	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдөр Цаг: 09 цаг 10 минут Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чин ван Чагдаржавын гудамж, Нийслэлийн түргэн тусламжийн төвийн сургалтын танхимд
Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ	
ТШЗ 29.2.	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: “Үгүй”
ТШЗ 31.1.	Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг: Шаардахгүй
ТШЗ 32.1	Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: “Ашиглахгүй”

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

№	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Савлагаа	Тоо хэмжих	Техник үзүүлэлт
Мах, махан бүтээгдэхүүн					
1	Үхрийн цул	кг	задгай	7200	MNS 2456:2009
2	Үхрийн татсан мах	кг	задгай	2880	Мах,өөхний харьцаа70/30 байх, махны физик химийн рН хэвийн . Мэдрэхүйн үзүүлэлтээр элдэв үнэр өнгөгүй, мал эмнэл зүйн лабораторийн шинжилгээний бичигтэй байх
3	Хонины сүүл	кг	задгай	35	Мал эмнэл зүйн лабораторийн шинжилгээний бичигтэй байх.
4	Хонины годон	кг	задгай	25	MNS 2457:2009, мал эмнэл зүйн лабораторийн шинжилгээний бичигтэй байх,1,2- р зэргийн мах байх, мэдрэхүйн үзүүлэлт хэвийн. Хадгалалт тээвэрлэлт хамгаалалтын стандарт хангасан байх.
5	Хонины цул	кг	задгай	9000	MNS 0703: 2014 вакуум ууттай. Хөлдүү байх, хадгалалт тээвэрлэлтийн стандарт хангасан байх . Тахианы махан дээр заасан стандартын дагуу бүх шинжилгээнд хамрагдсан байх.
6	Тахианы цээж	уут	2кг савлагаатай	288	MNS 0703: Хайрцагтай . Хөлдүү байх, мал эмнэл зүйн лабораторийн шинжилгээний бичигтэй байх
7	Тахианы мөч	кг	задгай	800	MNS 2456:2009, хөлдүү, мал эмнэл зүйн лабораторийн шинжилгээний бичигтэй байх, махны
8	Үхрийн ястай мах	кг	задгай	100	

					өнгө үзэмж мэдрэхүйн үзүүлэлт хэвийн байх.
9	Хонины хавирга	кг	задгай	700	MNS 2457:2009 мал эмнэл зүйн лабораторийн шинжилгээний бичигтэй байх, савлалт хадгалалт, тээвэрлэлтийн стандарт хангасан байх.
10	Гахайн мах	кг	задгай	280	MNS 0167:2012, хөлдүү байх, мал эмнэл зүйн лабораторийн шинжилгээний бичигтэй байх, савлагаа тээвэрлэлт, хадгалалт нь стандарт хангасан байх.
11	Хонины гулууз	кг	задгай	15	MNS 2457:2009 мал эмнэл зүйн лабораторийн шинжилгээний бичигтэй байх. Гулууз нь 20 кг-аас доошгүй жинтэй байх,
12	Тахианы гуя	кг	задгай	1400	MNS 0703: Хайрцагтай . Хөлдүү байх, Тахианы махан дээр заасан стандартын дагуу бүх шинжилгээнд хамрагдсан байх. Хадгалалт, тээвэрлэлтийн стандарт хангасан байх.
13	Утлагат хиам	кг	задгай	250	MNS 2060:2007 . Нитрит, давс нь стандартад заагдсаны дагуу байх. Үйлдвэрээс гарсан хадгалах хугацааг зөрчөөгүй шинэ байх.
14	Зайдас	кг	задгай	250	MNS 2060:2007 . Нитрит, давс нь стандартад заагдсаны дагуу байх.
15	Өндөг	ш	Хагарахгүйгээр савласан байх	35000	MNS 0095:2022 хангасан байх. 40-50 гр жинтэй. Нийтийн хоол үйлдвэрлэлд тохиромжтой.

					Лабораторийн шинжилгээний бичигтэй байх
Гурил, үр тариа					
16	Гурил дээд	кг	10 кг савлагаатай	288	БГ:045 MNS 0244: 2009. гуриланд байх ёстой цавуулаг ,шимт тэжээлийн бодисыг хангасан байх,
17	Гурил 1-р	кг	25 кг савлагаатай	288	БГ:045, MNS 0244: 2009. гуриланд байх ёстой цавуулаг ,шимт тэжээлийн бодисыг хангасан байх,
18	Элдэвтэй гурил	уут	12 ширхэгтэй	600	MNS5760:2020. Үйлдвэрийнх байх бөгөөд хадгалалтын хугацаа зөрчихгүй шинэ байх
19	Цагаан будаа	кг	25 кг савлагаатай	200	MNS ISO 3301:2000 , Гаднын хольцгүй, элдэв үнэргүй, өнгө цагаан, тунгалаг байх
20	Хөц будаа	уут	1 кг савлагаатай	288	MNS 4515:1997. гаднын хольцгүй , элдэв амт үнэргүй, савлагаа бүрэн бүтэн байх
21	Шар будаа	уут	1 кг савлагаатай	450	MNS0533:1998, гаднын хольцгүй ,элдэв амт үнэргүй,савлагаа бүрэн бүтэн байх.
22	Гурвалжин будаа	уут	1 кг савлагаатай	288	MNS6511:2015, гаднын хольцгүй,элдэв амт үнэргүй,савлагаа бүрэн бүтэн байх
23	Пүнтүүз Тунгалаг	уут	900 гр савлагаатай	300	Ууттай, тунгалаг , Шимт бодисын агууламж хангасан байх
24	Вандуй	кг	1 кг савлагаатай	144	MNS 4515:1997, гаднын хольцгүй. Элдэв эмт үнэргүй, савлагаа бүрэн бүтэн байх
25	Мушгиа гоймон	уут	350 гр савлагаатай	96	MNS 0142:1985, Цавуулаг, шимт бодисын агууламж стандарт хангасан байх
26	Шпагетти гоймон	уут	3 кг савлагаатай	220	MNS0142:86. Цавуулаг, шимт бодисын агууламж стандарт хангасан байх, уут савлагаа бүрэн бүтэн байх.

27	Лапша гоймон	уут	3 кг савлагаатай	84	MNS0142:86. Цавуулаг, шимт бодисын агууламж стандарт хангасан байх, уут савлагаа бүрэн бүтэн байх.
28	Алаг гоймон	уут	350 гр савлагаатай	500	MNS0142:86. Цавуулаг, шимт бодисын агууламж стандарт хангасан байх, уут савлагаа бүрэн бүтэн байх.
29	Хөндий гоймон	уут	500 гр савлагаатай	400	MNS0142:86. Цавуулаг, шимт бодисын агууламж стандарт хангасан байх, уут савлагаа бүрэн бүтэн байх.
30	Ёотон	хайрцаг	1 кг савлагаатай	72	MNS0142:86. Цавуулаг, шимт бодисын агууламж стандарт хангасан байх, уут савлагаа бүрэн бүтэн байх.
31	Элсэн чихэр	уут	1 кг савлагаатай	650	MNS CAC 212:2014 , өнгө цагаан. Гаднын элдэв хольц үнэргүй , савлагаа бүрэн бүтэн байх
32	Хуурай сүү	уут	500 гр савлагаатай	500	32% тослогтой. MNS 6720 :2018, зурамтгай чанаргүй байх
33	Үзэм	уут	1 кг савлагаатай	48	MNS CAC67:1999, хуурай, хольцгүй хог багатай байх
Хүнсний ногоо					
34	Төмс	кг	задгай	6200	MNS 0258:2006 Хатааж сэврээсэн. Шинэ ургацын Төмс, бүдүүн ногоо нь хог шороогүй, элдэв муудсан үнэргүй, хөгц үүсээгүй байх.MNS 5684:2006 стандарт хангасан уут савлагаатай байх. Генийн өөрчлөлтгүй байх
35	Лууван	кг	задгай	2880	MNS 0255:2007. Намар эрт ургацын , хадгалалтын стандарт зөрчөөгүй, шинэ, хэмжээ дундаас дээш,

					савлагааны стандарт хангасан байх, пестицидийн үлдэгдэлгүй байх
36	Байцаа	ш	задгай	4000	MNS 0268:1973. Гаднах навч нь салбараагүй, шинэ байх. Хадгалалт тээвэрлэлт, савлалтын стандарт хангасан байх. Пестицидийн үлдэгдэлгүй байх
37	Шар манжин	кг	задгай	900	MNS 0271:1972. Гаднын бохирдол, элдэв хог шороогүй стандартын дагуу хадгалсан , пестицидийн үлдэгдэлгүй байх
38	Хүрэн манжин	кг	задгай	900	MNS0268:2020 . Гаднын бохирдол, элдэв хог шороогүй стандартын дагуу хадгалсан , пестицидийн үлдэгдэлгүй байх
39	Ногоон сонгино	боодол	задгай	624	MNS 0268: 2021. Боодолтой, гэмтэж муудаагүй. Генийн өөрчлөлтгүй, пестицидийн үлдэгдэлгүй байх.
40	Сонгино	кг	задгай	2880	MNS 0260:1982. хэмжээ дундаас дээш , хальс нь эвдэрч гэмтээгүй. Гаднын хольцгүй пестицидийн үлдэгдэлгүй байх.
41	Сармис	уут	5 ширхэгтэй	520	MNS 0260:1982. боодолтой хөгцөрч муудаагүй, шинэ байх.
42	Сармисны гол	кг	задгай	250	MNS 0260:1983. Хадгалалт, савлалт, тээвэрлэлтийн стандарт хангасан байх.
43	Чинжүү /Амтат/	кг	задгай	576	MNS ISO 7563:2000 , хөлдөөгүй, муудаагүй, шинэ, хадгалалт тээвэрлэлтийн стандарт хангасан байх.
44	Шар хулуу	кг	задгай	150	MNS ISO 7563:2001, хөлдөөгүй

					муудаагүй, шинэ байх, хадгалалт тээвэрлэлтийн стандарт хангасан байх
45	Ногоон хулуу	ш	задгай	350	MNS ISO 7563:2002. хөлдөөгүй, муудаагүй, хадгалалт, тээвэрлэлтийн стандарт хангасан байх. Пестицидийн үлдэгдэлгүй байх
46	Брокли	кг	задгай	300	MNS 0255:2020. өнгө тод ногоон жигд, хөлдөөгөө, гаднах бохирдолгүй, пестицидийн үлдэгдэлгүй байх
47	Помидор	кг	задгай	650	MNS ISO 7563:2000 Хөлдөлт үүсээгүй, хөгц мөөгөнцөргүй, пестицидийн үлдэгдэлгүй, Гений өөрчлөлтгүй. Савлалт, хадгалалт, тээвэрлэлтийн стандарт хангасан байх.
48	Ногоон огурци	кг	задгай	600	MNS ISO 7563:2001. Хөлдөлт үүсээгүй, хөгц мөөгөнцөргүй, пестицидийн үлдэгдэлгүй, Гений өөрчлөлтгүй. Савлалт, хадгалалт, тээвэрлэлтийн стандарт хангасан байх.
49	Юуцай	кг	задгай	350	MNS ISO 7563:2002. хөлдөөгүй, муудаагүй, хадгалалт, тээвэрлэлтийн стандарт хангасан байх. Пестицидийн үлдэгдэлгүй байх
50	Бууцай	кг	задгай	180	MNS ISO 7563:2000. хөлдөөгүй, хөгц мөөгөнцөр үүсээгүй, пестицидийн үлдэгдэлгүй, Гений өөрчлөлтгүй байх.
51	Савхан цагаан мөөг	уут	150 гр савлагаатай	144	MNS ISO 7563:2001, хөгц үүсээгүй, савлалт, хадгалалт, тээвэрлэлтийн стандарт хангасан байх.

52	Бор мөөг	кг	задгай	96	MNS ISO 7563:2002, Мөөгний чиглэлийн агууламж хангасан байх. Хөгц мөөгөнцөргүй, хадгалалт, тээвэрлэлт, савлалтын стандарт хангасан байх.
53	Дарсан шар манжин	ш	500 гр савлагаатай	96	MNS ISO 7563:2001. Амт өнгө стандартын дагуу в савлалт, хадгалалтын стандарт хангасан байх.
54	Салад навч	кг	задгай	120	MNS ISO 7563:2001, Шинэлэг байдлаа хадгалсан, навч нь бүтэн, хөлдөөгүй байх, гаднын бохирдолгүй. Уут савлалт, хадгалалт, тээвэрлэлт стандарт хангасан байх.
Амталгааны материал					
55	Давсалсан огурцы	ш	720 мл савлагаатай	930	тунадасжилт үүсээгүй , амт өнгө үйлдвэрлэлийн стандарт хангасан байх
56	Давсалсан огурцы	ш	2500 мл савлагаатай	24	тунадасжилт үүсээгүй , амт өнгө үйлдвэрлэлийн стандарт хангасан байх
57	Өөг салат	ш	720 мл савлагаатай	24	720 мл-ын шилэн савлагаатай, үйлдвэрээс гарсан хугацааг баримтлах.
58	Ананас лаазтай	ш	340 гр савлагаатай	20	Цэвэр жин 340 гр. Гений өөрчлөлтгүй, лаазалсан . Лааз нь эвдэрч гэмтээгүй байх
59	Лаазтай мөөг	ш	400 гр савлагаатай	150	Лааз нь эвдэрч гэмтээгүй, хадгалалтын горим зөрчөөгүй.
60	Эрдэнэ шиш	ш	340 гр савлагаатай	380	Лаазалсан бүтээгдэхүүн. НАССР. ISO 22000-2018 тэмдэгтэй, Гений өөрчлөлтгүй байх
61	Вандуй	ш	400 гр савлагаатай	370	400 гр-ын савлагаатай, лаазалсан бүтээгдэхүүн. НАССР. ISO 22000-2018 тэмдэгтэй, Генийн өөрчлөлтгүй байх

62	Гахайн амтлагч	ш	500 гр савлагаатай	48	Халуун ногооны чихэрлэг зөөлөн амттай соус, савлалт, хадгалалт,
63	Туна	ш	250 гр савлагаатай	400	250 гр, лаазалсан, тослог 60%. Лааз нь эмтэрч гэмтээгүй байх.
64	Ургамлын тос	ш	1 литр савлагаатай	1920	1л савлагаатай, Гений өөрчлөлтгүй, 100% ургамлын цэвэршүүлсэн тос
65	Гүнжидийн тос	ш	450 мл савлагаатай	50	SC10234052230214 тусгай зөвшөөрөлтэй. Элдэв хурц үнэргүй, тунадасжилт үүсээгүй байх.
66	Цөцгийн тос	уут	1 кг савлагаатай	144	MNS 6652:2017 ,82 % тослогтой. Савлагаа, хадгалалт, тээвэрлэлтийн стандарт хангасан байх.
67	Шар тос	ш	300 гр савлагаатай	30	MNS 4528:2011 ,300 гр савтай
68	Майонез	ш	2 литр савлагаатай	350	ГОСТ-53590, ICO-22000. Тослог, шимт бодисын агууламж заасан стандарт хангасан байх.
69	Бүлгүги соус	ш	840 гр савлагаатай	200	тунадасжилт үүсээгүй , чихэрлэг зөөлөн амттай.
70	Чихэрлэг соус	ш	735 мл савлагаатай	72	хадгалалт тээвэрлэлтийн хугацаа зөрчөөгүй байх , тунадасжилт үүсээгүй.
71	Соёо соус	ш	500 мл савлагаатай	72	цэвэр буурцганаас гаргаж авсан хоолны цуу нь өнгө жигд , тунадас үүсээгүй байх.
72	Йогуртан соус	ш	500 мл савлагаатай	48	Бүх төрлийн ногооны салат амтлагч
73	Кетчуп	ш	900 гр савлагаатай	200	900 гр, хуванцар савтай
74	Цуу	ш	100 гр савлагаатай	200	100 гр , шилэн савтай хоолны цуу , тунадасжилт үүсээгүй. Хадгалалт, тээвэрлэлтийн стандарт хангасан байх.

75	Гучужан	ш	170 гр савлагаатай	250	170 гр , хуванцар савтай. Халуун ногооны нухаш.
76	Хайрцагтай сухар	ш	1 кг савлагаатай	96	талхны нунтаг хатаамал. Хайрцаг сав эмтэрч гэмтээгүй. Шимт бодисын хэмжээ нь заасан стандарт хангаан байх.
77	Дүпү	ш	400 гр савлагаатай	240	MNS 5607:2006. Үйлдвэрээс гарсан хадгалалтын хугацаа зөрчөөгүй, шинэ зөөлөн ,элдэв амт үнэргүй байх.
78	Кимчи	ш	500 мл савлагаатай	240	500 мл-ын савлагаатай . Кимчи нь исэж муудаагүй. Хадгалалт, тээвэрлэлт, савлалтын стандарт хангасан байх.
79	Хийцтэй цай	ш	170 гр савлагаатай	136	170 гр-ын савлагаатай.MNS 5131:2002, уут савлагаа бүрэн бүтэн.
80	Аквар цай	хайрцаг	25 ширхэгтэй	288	Хайрцаг сав нь эвдэрч гэмтээгүй байх.
81	Гүрж ногоон цай	хайрцаг	21 ширхэгтэй	288	MNS 5864:2008. Пакеттай гүрж ногоон цай.
82	Сыр	Уут	24 ширхэгтэй	50	Импортын хуудсан бяслаг уутандаа 24,48 ширхэгтэй
83	Сыр Моцаррелла	кг	задгай	72	MNS CAC 262:2023. Хөгцөрч муудаагүй, шинэ байх. Хадгалалт, тээвэрлэлтийн стандарт хангасан байх.
84	Исгэгч	ш	500 гр савлагаатай	50	Гурилан бүтээгдэхүүн хөөлгөгч, вакум ууттай. Хадгалалтын хугацааны горим зөрчөөгүй байх.
85	Давс	ш	1 кг савлагаатай	250	MNS 5046:2019, 1 кг-ын савлагаатай , иодын агууламж заасан стандарт хангасан байх.
86	Миог	ш	100 гр савлагаатай	250	Хуурай, хатаамал, өнгө тод ногоон , зөөлөн далайн үнэртэй.

87	Далайн байцаа	уут	10 ширхэгтэй	48	Эвдэрч гэмтээгүй, уут савлагаа бүрэн бүтэн. Чийг аваагүй байх.
88	Уксус ногоон	ш	1000 мл савлагаатай	12	9% -ын сулруулсан цууны хүчил.
89	Уксус алим	ш	500 мл савлагаатай	24	тунгалаг шар өнгөтэй, алимьн зөөлөн амттай. Сулруулсан цууны хүчил
90	Зөгийн бал	ш	280 мл савлагаатай	90	Шимт бодисын агууламж хэвийн, тунадасжилт үүсээгүй байх.
91	Гүнжидийн үр	ш	50 гр савлагаатай	120	Шөл,салат амтлахад шууд хэрэглэнэ. Амт, үнэр нь хурц , уут савлагаа бүрэн бүтэн.
92	Шпагетти амтлагч	ш	500 гр савлагаатай	120	500-840 гр ын лаазтай, лааз нь эмтэрч гэмтээгүй байх.
93	Цагаан гаа	уут	25 гр савлагаатай	72	25 гр цаасан ууттай. Нунтаг хатаасан хэлбэрээр савлагдсан.
94	Лаврын навч	уут	20 гр савлагаатай	120	20 гр цаасан ууттай. Хатаасан хоолны амтлагч навч шөл гаргах зориулалттай .
95	Хуурай лимон	уут	10 гр савлагаатай	72	10 гр- ын савлагаатай. Цаасан ууттай.
96	Петрушка	ш	20 гр савлагаатай	72	20 гр цаасан ууттай. Хатаасан яншуй, шөл, салатанд хэрэглэнэ.
97	Хуажуу дайлуу	ш	30 гр савлагаатай	48	30 гр - ын савлагаатай, шөл 2- р хоол амтлах зориулалттай .
98	Карри	ш	140 гр савлагаатай	72	шахмал бор хүрэн өнгөтэй. Цаасан хайрцагтай дотроо битүүмжтэй. Үйлдвэрлэсэн Япон.
99	Гоньд	ш	20 гр савлагаатай	144	Хатаамал амтлагч бууз, банш, хуушуур зэрэг монгол хоолны амтлагч. Амт үнэр хурц байх.
100	Дашида	уут	1 кг савлагаатай	144	1 кг ууттай. Нунтаг хоолны амтлагч, .Уут савлагаа бүрэн бүтэн байх.
101	Кимчи перец	ш	40 гр савлагаатай	40	40 гр савлагаатай. Шөл амтлагч халуун ногоо.

102	Хар перец	ш	50 гр савлагаатай	250	50 гр цаасан ууттай. Нунтаг хар.
103	Жан	ш	800 гр савлагаатай	48	800 гр-ын хуванцар савлагаатай. Q/BZLD0001S. Буурцагийн амтлагч жан.
104	Томат. Паста	ш	400 гр савлагаатай	72	лаазалсан бүтээгдэхүүн.НАССР. ISO 22000-2018 тэмдэгтэй, Гений өөрчлөлтгүй байх
105	Хатаасан сонгино	ш	50 гр савлагаатай	50	Цаасан савлагаатай. Шөлөнд шууд хэрэглэх зориулалттай.
106	Хүнсний сода	ш	500 гр савлагаатай	24	Гидрокарбонат натри олон улсын нэршилтэй. Цаасан хайрцагтай. 500гр савлагаатай.
107	Тахиа амтлагч	ш	40 гр савлагаатай	72	40 гр цаасан ууттай, Тахиа амталж шарах зориулалттай. Химийн элдэв амт өнгө үнэр оруулагчгүй байх.
108	Крахмал	ш	200 гр савлагаатай	144	200 гр -ын савлагаатай. Төмсний хатаасан хэлбэрийн цардуул. Соус өтгөрүүлэх зориулалттай.
Жимс, жимсгэнэ					
109	Алим	кг	задгай	48	Гений өөрчлөлтгүй, хөгц мөөгөнцөр үүсээгүй. Шүүслэг шинэ байх. MNS CAC 299:2014, пестицидийн үлдэгдэлгүй байх.
110	Лийр /Бельги/	кг	задгай	45	Гений өөрчлөлтгүй, хөгц мөөгөнцөр үүсээгүй. Шүүслэг шинэ байх. Хадгалалт, савлалт, тээвэрлэлтийн стандарт хангасан байх.
111	Усан үзэм	кг	задгай	20	Гений өөрчлөлтгүй, хөгц мөөгөнцөр үүсээгүй. Шүүслэг шинэ байх. Хадгалалт, савлалт, тээвэрлэлтийн стандарт хангасан байх.
112	Мандарин	кг	задгай	40	Гений өөрчлөлтгүй, хөгц мөөгөнцөр үүсээгүй.

Commented [WU1]:

					Шүүслэг шинэ байх. Хадгалалт, савлалт,тээвэрлэлтийн стандарт хангасан байх.
113	Банана	кг	задгай	40	Гений өөрчлөлтгүй,хөгц мөөгөнцөр үүсээгүй. Шүүслэг шинэ байх. Хадгалалт, савлалт,тээвэрлэлтийн стандарт хангасан байх.
114	Аньс	ш	задгай	72	Байгалын цэвэр зэрлэг жимс болон түүнээс гаргаж авсан өтгөрүүлсэн шүүс/ тетрапак/ Хадгалалт,савлалт , тээвэрлэлтийн стандарт хангасан байх.
115	Улаан чавга	кг	задгай	6	Хатаамал улаан чавга , гаднын бохирдол хольцгүй байх . Хадгалалт, савлалт,тээвэрлэлтийн стандарт хангасан байх.
116	Чацаргана	кг	задгай	150	Таримал болон зэрлэг сортынх байх.
Сүү,сүүн бүтээгдэхүүн					
117	Шингэн сүү	л	задгай	285	MNS 0219:2011 ,тетрапак савалгаатай, тослогын хэмжээ 20- 30% байх. Гашилаагүй байх
118	Аарц	кг	задгай	200	MNS 4229: 2011 , аарц нь хэт исгэлэн биш, цэвэр сүүнээс гаргаж авсан бүтээгдэхүүн байх.
119	Айраг	л	задгай	210	MNS 4229: 2011 , хахраагүй, цэвэр гүүний саамын айраг байх
120	Ааруул	кг	задгай	10	MNS 4229: 2011, шимт бодисын агууламж стандарт хангасан байх, ааруул нь цэвэр аарцных нь байх.

121	Зөөхий	ш	500 гр савлагаатай	120	MNS 6652:2017 тослогын хэмжээ 15- 20% байх
122	Өрөм/тогооны/	ш	нэг хавтгай	4	MNS 4528:2011 ,Хавтгай, шинэ , хөгц үүсээгүй байх.
Талх, гурилан боов,амттан					
123	Хэвийн боов	ш	задгай	20	MNS 0461 :2022 Үйлдвэрээс гарсан хугацаа хэтрээгүй, шинэ байх
124	Талх	ш	уут	150	MNS 4661:2009 . Шинэ хөгцөрч муудаагүй, хадгалалт, тээвэрлэлт, савлалтын стандарт хангасан байх
125	Сэндвич талх	ш	уут	70	MNS 4661:2009 . Шинэ хөгцөрч муудаагүй, хадгалалт, тээвэрлэлт, савлалтын стандарт хангасан байх
126	Хотдог талх	ш	уут	85	MNS 4661:2009 . Шинэ хөгцөрч муудаагүй, хадгалалт, тээвэрлэлт, савлалтын стандарт хангасан байх
127	Бургерийн талх	ш	уут	85	MNS 4661:2009 . Шинэ хөгцөрч муудаагүй, хадгалалт, тээвэрлэлт, савлалтын стандарт хангасан байх
128	Цайны печень	ш	уут	48	MNS 0461 :2022, 250- 500 гр ын ууттай .
129	Еэвэн	ш	уут	1	MNS 0461 :2022 ууттай байх Эвдэрч_хугараагүй байх
130	Кофе	ш	ш	16	MNS ICO 3509:2000 хангасан байх, Шилэн савтай. Үнэр амтаа
131	Кофены сүү	ш	ш	16	MNS ICO 3509:2000 хангасан байх, Шилэн савтай.
132	Чихэр	кг	задгай	30	MNS 0395:1981 ,MNS 0444:1987 . Чихэр нь Хатуу , зөөлөн холимог байх.
Бэлэн байдлын хүнс					
133	Бэлэн гоймон Nongshim	ш	500 гр савлагаатай	60	500 мл ын зориулалтын савлагаатай, хайрцаг

					сав эмтэрч гэмтээгүй байх.
134	Цэвэр ус	ш	330 мл савлагаатай	480	MNS 5007:2007. 0,33 мл-ын хэмжээтэй хуванцар савлагаатай
135	Цэвэр ус	ш	500 мл савлагаатай	100	MNS 5007:2007. 0,5мл-ын хэмжээтэй хуванцар савлагаатай
136	Аягатай кофе	ш	500 мл савлагаатай	10	MNS ICO 3509:2000 хангасан байх, 1 удаагийн савтай.
137	Цэвэр жүүс	ш	1 литр савлагаатай	50	MNS 0687:2003 , Тунадасжилт үүсээгүй . Хадгалалт ,тээвэрлэлт, савлалтын стандарт хангасан байх.
138	Ундаа	ш	330 мл савлагаатай	120	MNS 0687-3:2015 0.33 мл-ын хэмжээтэй хуванцар савтай

Зураг, төсөл

Шаардлагатай бол барааны эскиз, зургийг хавсаргана.

Шалгалт, туршилт

[Захиалагч оролцогчоос нийлүүлэх гэж буй бараанд үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилт хийсэн болохыг нотлох баримт, үүнтэй холбоотой мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.

Шаардлагатай тохиолдолд захиалагч загвар, дээжийг шалгаж, туршиж болох ба шалгалт, туршилт хийсний үр дүнд тухайн загвар, дээжийн үндсэн шинж чанар алдагдсан, зориулалтын дагуу дахин ашиглах боломжгүй болсон тохиолдолд оролцогчид буцааж олгохгүй тухай техникийн тодорхойлолтод заана. Бусад тохиолдолд гэрээ байгуулсны дараа шалгарсан оролцогчийн загвар, дээжээс бусад загвар, дээжийг буцааж олгоно.

Загвар, дээжийг хэрхэн шалгах, турших тухай тодорхой заана.]

Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь доор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Барааны нэр:

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт (Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)	Санал болгож буй техникийн тодорхойлолт (захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн	Тайлбар (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)

		тодорхойлолтыг бичнэ үү.)	
1			
2			
3			
...			

[Үнэлгээний хороо худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д нийтэлсэн техникийн тодорхойлолтын жишиг нөхцөл, стандарт, загварыг баримтлан техникийн тодорхойлолтыг боловсруулна.]

Бараа нийлүүлэлтийн хуваарь

[Захиалагч доорх хүснэгтийн 1-6 хүртэлх баганыг, тендерт оролцогч 7 дугаар баганыг бөглөнө]

№	Барааны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Өгөгдлийн хүснэгтэд заасан барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа	
					Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа)	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа (Оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7
1	Хүнсний материал			НТТ	2024.04.01-ны өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл	[6 дугаар баганад заасан хугацаанд багтаан нийлүүлэхээр санал болгож буй хугацааг бичих]

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч ТӨХ-д тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна ТШЗ-ны 35.1.6-д заасан нэг буюу хэд хэдэн хүчин зүйлийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр бусад аливаа шалгуур үзүүлэлт, аргачлалыг үнэлгээнд харгалзахгүй.

“Ашиглахгүй

V БҮЛЭГ.ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТУУД

Маягт 1.Тендер илгээх маягт

Маягт 2.Барааны үнийн задаргаа

Маягт 3.Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл

Маягт 4.Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Маягт 5.Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Маягт 6.Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтад [үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцохтой холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна. Үүнд:
 - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
 - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
 - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй;
 - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт **[“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих]**. **[Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих]**.
5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш **[30 ба түүнээс дээш хоногийн тоо]** хоногийн хугацаанд хүчинтэй байна.¹
6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр эвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

¹ Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол “5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.” гэж сольж бичнэ үү.

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг,
байгууллагын тамга, тэмдэг]:
Хаяг:

Маягт 2 **Барааны үнийн задаргаа**

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
№	Барааны нэр	Гарал үүслийн улс ²	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Нэгж үнэ	Нэр төрөл бүрийн бүгд үнэ (4x6)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ	Бараа нийлүүлэхэд ногдох татвар, хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (7+8+9)	Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх ³
1										Тийм/Үгүй
2										
...										
Тендерийн нийт үнэ										

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]:

² ТШЗ-ны 18.6.2-ын дагуу ирүүлсэн баримт бичигт дурдсан барааны гарал үүслийн талаарх мэдээлэлтэй ижил байна.

³ Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх гэдэгт "тийм" гэж бөглөсөн бол түүнийг нотлох баримт бичгийг хавсаргана.

Маягт 3 **Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

Маягт 4 **Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Маягт 5 **Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл**

Оролцогчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

Маягт 6 **Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт**

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Хүний эмзэг мэдээлэлд хамаарах хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		
4.		
5.		

VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Санамж

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж бараа худалдан авахад энэхүү гэрээний нөхцөлийг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас бараа, түүнтэй холбогдох үйлчилгээг худалдан авах харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн бараа худалдан авах нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн бараа худалдан авахад хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. ГТН-д заасан зарим жишээ, нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
7. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан гэрээ байгуулах албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалттай танилцаж, судалсан байх шаардлагатай болохыг анхаарна уу.

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ.ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

- 1.1. Гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл нь дор дурдсан утгыг агуулна:
 - 1.1.1. “Бараа” гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;
 - 1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;
 - 1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.4. “Нийлүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нэрлэснийг;
 - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
 - 1.1.7. “Бараа нийлүүлэх нөхцөл” гэж Захиалагчийн техникийн тодорхойлолтод нийцүүлж Тендерт тусгасан бараа бэлтгэх, нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг ойлгоно. Тендерт тусгайлан заагаагүй бараа нийлүүлэх нөхцөлийг Техникийн тодорхойлолтод тусгаснаар ойлгоно. Хуулийн 30.2, 34.2-т зааснаар хэлэлцээ хийсэн тохиролцоо нь Гэрээнд тусгагдсан бол Бараа нийлүүлэх нөхцөлийн нэг хэсэг болно.
 - 1.1.8. “Бараа нийлүүлэх газар” гэж барааг хүлээлгэн өгөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;
 - 1.1.9. “Доголдол” гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;
 - 1.1.10. “Баталгаат хугацаа” гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад бараанд илэрсэн доголдлыг нийлүүлэгч хариуцах хугацааг;
 - 1.1.11. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлага гаргах хугацааг;

- 1.1.12. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
- 1.1.13. “Нийлүүлэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс томилогдсон этгээдийг;
- 1.1.14. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.
- 1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:
- 1.2.1. Ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно.
- 1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.
- 1.2.3. Зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.
- 1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.
- 1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ

- 2.1 Нийлүүлэгч нь гэрээнд заасан бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан

- хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.
- 2.2 Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад эдгээрт өөрчлөлт орох зайлшгүй шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна.
- 2.3 ГЕН-ийн 2.2-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.
- 2.4 Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг хүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.
- Бараа нийлүүлэх газар 2.5 Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана.
- Бараа нийлүүлэх хугацаа, түүнийг сунгах 2.6 Бараа нийлүүлэх хугацааг нийлүүлэлтийн хуваарийг үндэслэн ГТН-д заана.
- 2.7 Нийлүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд бараа нийлүүлэлтийн хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:
- 2.7.1 Захиалагч ГЕН-ийн 2.4-д заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;
- 2.7.2 Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон.
- 2.8 Захиалагч ГЕН-ийн 2.7-д заасан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл Нийлүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.
- 2.9 ГЕН-ийн 2.7.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй.
- Барааг хүлээлгэн өгөх 2.10 Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.
- 2.11 Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ.
- Барааны гарал үүслийн улс 2.12 Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна.
- 2.13 Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийг нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь заавал Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна.
- Баглаа боодол 2.14 Нийлүүлэгч барааг ГЕН-ийн 2.5-д заасан газар хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудах, дутах зэрэг доголдлоос урьдчилан сэргийлэх сав, баглаа боодлыг ГТН-д заасны дагуу хангана.

- 2.15 Сав, баглаа боодол, түүний хаягдал нь хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар сонгоно. Сав, баглаа боодолд хууль тогтоомжоор хориглосон материал ашиглахыг хориглоно.
- 2.16 Нийлүүлэгч баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг мөрдөнө.
- Худалдааны нөхцөл 2.17 Гэрээнд Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хэрэглэх бол тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 20.6-д заасан нөхцөлийг ГТН-д тусгана.
- 2.18 ГТН-д заагаагүй бол Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
- Гүйцэтгэлийн баталгаа 2.19 Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Нийлүүлэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Нийлүүлэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.
- 2.20 Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Нийлүүлэгчийн Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна:
- 2.20.1 Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;
- 2.20.2 Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;
- 2.20.3 Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.
- 2.21 Захиалагч гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Нийлүүлэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.
- 2.22 ГЕН-ийн 2.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Нийлүүлэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.
- 2.23 Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 4.11-д заасан Чанарын баталгаа гаргасан тохиолдолд Гүйцэтгэлийг баталгааг чөлөөлнө.
- ГУРАВ. ЗАХИАЛАГЧ**
- Барааг хүлээн авах 3.1 Захиалагч нь барааг хүлээн авч, хүлээлцсэн баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.
- Шалгалт, туршилт 3.2 Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй.

- Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ.
- 3.3 Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ.
- 3.4 ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна.
- 3.5 Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдолтой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.
- 3.6 Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна.
- Гэрээний үнэ 3.7 Гэрээний үнийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 3.8 Гэрээний үнэд хуулийн 40.4-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д заана.
- Төлбөр төлөх 3.9 Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Нийлүүлэгчид төлнө.
- 3.10 Нийлүүлэгчийн хүсэлтээр Захиалагч Бараа нийлүүлэх хугацааг ГЕН-ийн 2.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.
- 3.11 Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.
- 3.12 Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.
- 3.13 ГЕН-ийн 3.8-д заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.
- 3.14 Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.
- 3.15 Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс суутгана.

ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА

- Захиалагчийн хүлээх эрсдэл 4.1. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:
- 4.1.1. Барааг захиалагчид шилжүүлснээс хойш бараа нь ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар гэмтсэн, устсан;

- 4.1.2. Нийлүүлэгч Барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх тодорхой үйлдэл хийсэн боловч Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн аваагүй (доголдолтой бараанд хамаарахгүй) байх хугацаанд ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар Бараа гэмтсэн, устсан.
- Даатгал 4.2. Нийлүүлэгч нь барааг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрсдэлээс хамгаалж ГТН-д заасны дагуу даатгуулж, даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг Захиалагчид ирүүлнэ. Даатгалын хураамжийг Нийлүүлэгч хариуцна.
- Доголдол 4.3. Захиалагч бараа, дагалдах үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар Нийлүүлэгчид мэдэгдэнэ.
- 4.4. Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор барааны далд хэсгийг нээх, шалгалт, туршилт хийх эрхтэй.
- 4.5. Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид өгнө.
- 4.6. Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр Нийлүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.
- 4.7. Нийлүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана.
- 4.8. Захиалагчийн гаргасан зардлыг Нийлүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө.
- 4.9. Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас суутгаж болох бөгөөд Чанарын баталгаа хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Нийлүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнө.
- Чанарын баталгаа 4.10. Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг ГТН-д заана.
- 4.11. ГТН-д заасан бол чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно.
- 4.12. Нийлүүлэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаажуулж болно.
- 4.13. ГЕН-ийн 4.12-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.
- 4.14. Баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Бараанд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.

- | | |
|---|--|
| Алданги | <p>4.15. ГЕН-ийн 4.7-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Нийлүүлэгчид олгоно.</p> <p>4.16. ГЕН-ийн 4.7-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.</p> <p>4.17. Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.</p> <p>4.18. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид төлнө.</p> |
| Оюуны өмчийн эрх зөрчих | <p>4.19. Барааг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсэн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.</p> |
| Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал | <p>4.20. Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.10-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.</p> <p>4.21. Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.</p> <p>4.22. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцөж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.</p> <p>4.23. Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Нийлүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Нийлүүлэгч ГЕН-ийн 2.7-д заасан хүсэлт гаргаж болно.</p> |
| Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа | <p>4.24. Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нөгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.</p> <p>4.25. Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд эсхүл</p> |

Нийлүүлэгч ГЕН-ийн 2.13-т заасныг зөрчсөн бол нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.

ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

Гэрээнээс татгалзах,
гэрээг цуцлах үндэслэл

- 5.1. Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээнээс татгалзах эсхүл гэрээг цуцлах эрхтэй:
 - 5.1.1. Нийлүүлэгч гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч нэмэлт хугацаанд гүйцэтгээгүй;
 - 5.1.2. Бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон;
 - 5.1.3. Нийлүүлэгч ГЕН-ийн 6.5-д заасан үүргээ зөрчсөн нь тогтоогдсон.
 - 5.1.4. Нийлүүлэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй.

Гэрээнээс татгалзах,
гэрээг цуцлах мэдэгдэл

- 5.2. Нийлүүлэгч тендерт оролцох буюу бараа нийлүүлэх явцдаа авлига өгсөн, залилах гэмт хэрэг үйлдсэн нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.
- 5.3. Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно.
- 5.4. Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.
- 5.5. Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээг дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.

ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

Төлөөлөгч

- 6.1. Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 6.2. Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна.
- 6.3. Гэрээ хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ.
- 6.4. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

- | | |
|----------------------------------|--|
| Туслан гүйцэтгэгч | <p>6.5. Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж байгаа тохиолдолд Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт зааснаас илүү хувийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.</p> <p>6.6. Туслан гүйцэтгэгчийн аливаа зөрчлийг (хугацаа хэтрүүлэх, ажлын доголдол гэх мэт) Нийлүүлэгч хариуцах бөгөөд Туслан гүйцэтгэгч өөрчлөгдсөн тохиолдолд ГЕН-ийн 2.3-д заасан журмыг баримтална.</p> |
| Нууцлал | <p>6.7. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.</p> <p>6.8. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.</p> |
| Мэдэгдэл | <p>6.9. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.</p> <p>6.10. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.9 -д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.</p> <p>6.11. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан Төлөөлөгчийн хаягаар илгээнэ.</p> <p>6.12. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:</p> <p>6.12.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн;</p> <p>6.12.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.</p> <p>6.13. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.</p> <p>6.14. ГЕН-ийн 6.13-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.</p> |
| Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах | <p>6.15. Дараах тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна:</p> <p>6.15.1. ГЕН-ийн 2.8-т заасны дагуу хугацаа сунгагдсан;</p> <p>6.15.2. үнийн тохируулга хийсэн.</p> |

- Маргаан шийдвэрлэх
- 6.16. Гэрээний нэмэлт, өөрчлөлтөд талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
 - 6.17. ГЕН-ийн 6.15-д зааснаас бусад тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.
 - 6.18. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
 - 6.19. Талууд зөвшилцөн, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.5.	Бараа нийлүүлэх газар: Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Нийслэлийн түргэн тусламжийн төвийн Автобааз
ГЕН 2.6.	Бараа нийлүүлэх хугацаа: 2024.04.01-2025.04.01 Барааг үе шаттай нийлүүлэх бол үе шатны хугацаа: [огноо бичих эсхүл нийлүүлэлтийн хуваарь байгаа бол түүнийг ишлэх]
ГЕН 2.10.	Бараа хүлээлгэн өгөх нөхцөл: Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Нийслэлийн түргэн тусламжийн төвийн Авто бааз Бараанд холбогдох баримт бичиг: нэхэмжлэх, зарлагын баримтын хамт хүлээлгэн өгөх Угсралт, суурилуулах: байхгүй
ГЕН 2.14.	Баглаа, боодол: [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөл, шаардлагыг тодорхой бичих.] [Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг бичих] Баглаа, боодлын шаардлага: Жишээ нь: [Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн, хур тунадас болон бусад бүх нөхцөлийг хангалттай тэсвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгохдоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, тээвэрлэлтийн цэг бүрд ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлсийг харгалзсан байна гэх мэт]
ГЕН 2.17.	Худалдааны нөхцөл: “Тийм” Incoterms 2020, DDP, Ulaanbaatar, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, НТТТ-ийн Авто бааз
ГЕН 3.8.	Үнийн тохируулга хийх аргачлал: Үнэ тохируулахгүй тогтмол байна.
ГЕН 3.9.	Төлбөр төлөх хугацаа: [он, сар, өдөр] Төлбөрийг хэсэгчилсэн төлөх тохиолдолд төлбөр төлөх үе шатны хугацаа: [он, сар, өдөр]
ГЕН 4.2.	Даатгал: Шаардахгүй.
ГЕН 4.10.	Баталгаат хугацаа:

	Чанарын шаардлага хангаагүй бараа бүтээгдэхүүнийг ажлын 3 хоногт солих.
ГЕН 4.11	Чанарын баталгаа: Чанарын баталгаа шаардах эсэх: шаардахгүй
ГЕН 4.17.	Нийлүүлэгчийн төлөх алданги: Алданги тооцох эсэх: “Тийм” Алдангийн хувь: гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс хоног тутамд 0.1 хувиар тооцох.
ГЕН 4.18.	Захиалагчийн төлөх алданги: Алданги тооцох эсэх: “Тийм” Алдангийн хувь: 0

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.
Дугаар № **[Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]**

Нэг талаас **[захиалагчийн нэрийг бичих]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэрийг бичих]** (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Бараа” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь **[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих]** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Нийлүүлэгч **[Нийлүүлэгчийн нэрийг бичих]**-ийн харилцах **[Банкны нэрийг бичих]** банкны **[дансны дугаар бичих]** дугаар дансанд шилжүүлнэ.
3. Доор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - 3.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;
 - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
 - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
 - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
 - 3.6. Техникийн тодорхойлолт;
 - 3.7. Бараа нийлүүлэлтийн хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
 - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:
 - 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын _____ үсэг]

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: **2024.02.08**
Тендер шалгаруулалтын төрөл: Бараа
Тендер шалгаруулалтын нэр: **Хоол хүнсний хангамжийн материал худалдан авах**
Тендер шалгаруулалтын дугаар: **НТТТ/202401003**
Нийт төсөвт өртөг: **632,529,400**
Тендер шалгаруулалтын арга: Нээлттэй

1. **Нийслэлийн түргэн тусламжийн төв** нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: **“Үгүй”**
3. Тендерийг **2024 оны 03 дугаар 04-ний өдрийн 09 цаг 00 минутаас** өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг **2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн, 09 цаг 10 минутад** нээнэ.
4. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: **“Зөвшөөрөхгүй”**
5. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **“Эрхгүй”**
6. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 өдрийн хугацаанд хүчинтэй байна.
7. Тендерийн баталгаа шаардах эсэх: **“Тийм”**
Баталгааны дүн: 3,162,647 төгрөг
8. Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: **“Үгүй”**
9. Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: **“Үгүй”**
10. Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

ЗАХИАЛАГЧИЙН ХАЯГ:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чин ван Чагдаржавын гудамж, НТТТ-ийн төв байр
Утас: 11-321811, 88297070